

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР

ИНДЕКС: E041101
ЭЛСЭГЧИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН: Бакалавр
СУРАЛЦАХ ЖИЛ: 1.5-2 жил



ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО. Салбарын хөгжлийн чиг хандлага, ажил олгогчийн шалгуур шаардлагад нийцсэн санхүүгийн тайлан, мэдээнд дүн шинжилгээ хийх, удирдлагын шийдвэр гаргах, нягтлан бодох бүртгэлийн онолын болон судалгаа шинжилгээний орчин үеийн арга зүйн мэдлэг, чадвартай, олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн, судлаачийг бэлтгэхэд оршино.

ЗОРИЛТ 01. Нягтлан бодох бүртгэлийн салбарын хөгжлийн чиг хандлага, үндэсний болон олон улсын стандарт шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөрөөр чанартай сургалт явуулна.

ЗОРИЛТ 02. Мэргэжлийн болон судлаачийн ёс зүйтэй, мэргэжлийн өндөр ур чадвартай судлаачийг бэлтгэнэ.

МЭРГЭЖЛИЙН СУУРЬ ХИЧЭЭЛҮҮД

- ❖ Шинжлэх ухааны судалгааны арга зүй
- ❖ Тоон болон чанарын судалгааны арга зүй
- ❖ Ахисан түвшний экономикс
- ❖ Стратегийн менежмент II
- ❖ Англи хэл

ХӨТӨЛБӨРӨӨР ОЛГОХ МЭДЛЭГ

- ❖ Эрдэм шинжилгээний, судалгааны онол, арга зүйн мэдлэг эзэмшүүлэх
- ❖ Нийгэм, эдийн засаг болон мэдээллийн технологийн мэргэжлийн мэдлэг
- ❖ Мэргэжлийн болон судлаачийн ёс зүйн тухайн мэдлэг
- ❖ Нягтлан бодох бүртгэлийн онолын чиг хандлага болон практик хэрэглээний мэдлэг

СОНГОН СУДЛАХ ХИЧЭЭЛҮҮД

- ❖ Олон улсын эдийн засаг, санхүү II
- ❖ Аудит II
- ❖ Хөрөнгийн үнэлгээ II
- ❖ Хөрөнгө оруулалтын менежмент II
- ❖ Санхүүгийн гүнзгийрүүлсэн шинжилгээ
- ❖ Ахисан түвшний татварын бүртгэл
- ❖ Санхүүгийн технологи
- ❖ Дижитал санхүү
- ❖ Мэргэжлийн ёс зүй
- ❖ СТОУС-ийн чиг хандлага
- ❖ Ахисан түвшний санхүүгийн менежмент

ХӨТӨЛБӨРӨӨР ЭЗЭМШИХ ЧАДВАР

- ❖ Багаар ажиллах ур чадвар, манлайлах, удирдах
- ❖ Харилцааны болон гадаад хэлээр харилцах, ашиглах
- ❖ Тоон өгөгдөл цуглуулах, боловсруулах, шинжлэх, дүгнэх
- ❖ Аливаа асуудлыг системтэй төлөвлөх, харьцуулах, тунгаан боловсруулах

ЗОРИЛТ 03. Орчин үеийн нягтлан бодох бүртгэлийн салбарын удирдлагын шийдвэр гаргахад шаардлагатай зардал удирдлагын бүртгэл, ахисан түвшний НББ, аудит, СТОУС-ийн ахисан түвшний чадвартай судлаач, мэргэжилтэн бэлтгэнэ.

ЗОРИЛТ 04. Суралцагчдад ахисан түвшний судалгаа, шинжилгээний ажлыг хийх, орчин үеийн судалгааны арга зүйг эзэмшүүлнэ.

МЭРГЭШҮҮЛЭХ ХИЧЭЭЛҮҮД

- ❖ Удирдлагад зөвлөгөө өгөх үйлчилгээ
- ❖ Ахисан түвшний санхүүгийн менежмент
- ❖ Гүйцэтгэлийн удирдлага
- ❖ Ахисан түвшний НББ, тайлагнал
- ❖ СТОУС-ийн чиг хандлага
- ❖ Мэргэжлийн судалгаа, онолын семинар
- ❖ Магистрын дипломын ажил
- ❖ Магистрын мэргэжлийн дадлага

МЭРГЭШҮҮЛЭХ ХИЧЭЭЛЭЭР ЭЗЭМШИХ МЭДЛЭГ, УР ЧАДВАР

- ❖ Санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргах, удирдлагад зөвлөгөө өгөх
- ❖ Ахисан түвшний нягтлан бодох бүртгэл, зардал удирдлагын бүртгэл, шинжилгээ хийх
- ❖ Байгууллагын санхүүгийн тайланд аудит болон хөрөнгийн үнэлгээ хийх
- ❖ Салбарын хүрээнд тулгамдсан асуудлыг судлах, шинжилгээ хийх, шийдвэр гаргах

АЖЛЫН БАЙР

- ❖ Санхүүгийн байгууллагын удирдах ажилтан
- ❖ Ерөнхий нягтлан бодогч (санхүүч)
- ❖ Ахлах нягтлан бодогч
- ❖ Татварын байцаагч
- ❖ Аудитор
- ❖ Судлаач багш

ХӨТӨЛБӨРИЙН ДАВУУ ТАЛ

Энэхүү хөтөлбөрөөр суралцсанаар Мандах Их Сургууль болон Швейцар улсын “Open University Switzerland Economics and Technology” сургуулийн хамтарсан ХОС ДИПЛОМ олгох хөтөлбөр, Япон улсын Тохоку их сургуулийн 1+1 хамтарсан хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангаснаар хамрагдах боломжтой юм